

**МОНГОЛ УЛСЫН ДИПЛОМАТ БОЛОН АЛБАН ПАСПОРТ ЭЗЭМШИГЧИД,
БҮГД НАЙРАМДАХ ЧИЛИ УЛСЫН ДИПЛОМАТ, АЛБАН БОЛОН ТУСГАЙ
ПАСПОРТ ЭЗЭМШИГЧДИЙГ ВИЗЭЭС ЧӨЛӨӨЛӨХ ТУХАЙ МОНГОЛ УЛСЫН
ЗАСГИЙН ГАЗАР, БҮГД НАЙРАМДАХ ЧИЛИ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР
ХООРОНДЫН ХЭЛЭЛЦЭЭР**

Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Чили Улсын Засгийн газар (цаашид “Талууд” гэнэ),

Монгол Улс, Бүгд Найрамдах Чили Улсын ард түмэн болон Засгийн газрын хоорондын найрамдалт харилцааг бэхжүүлэхийг эрмэлзэн,

Дараахь зүйлийг хэлэлцэн тохиров:

1 дүгээр зүйл

Хүчин төгөлдөр дипломат, албан болон тусгай паспорт эзэмшиж буй Бүгд Найрамдах Чили Улсын иргэд Монгол Улсын нутаг дэвсгэрт ер /90/ хоногоос илүүгүй хугацаагаар визгүй зорчиж, дамжин өнгөрч, байж, гарч болно. Дурдсан хугацааг Монгол Улсын Засгийн газрын эрх бүхий байгууллага ер /90/ хоногоос илүүгүй хугацаагаар сунгаж болно.

2 дугаар зүйл

Хүчин төгөлдөр дипломат болон албан паспорт эзэмшиж буй Монгол Улсын иргэд Бүгд Найрамдах Чили Улсын нутаг дэвсгэрт ер /90/ хоногоос илүүгүй хугацаагаар визгүй зорчиж, дамжин өнгөрч, байж, гарч болно. Дурдсан хугацааг Бүгд Найрамдах Чили Улсын Засгийн газрын эрх бүхий байгууллага ер /90/ хоногоос илүүгүй хугацаагаар сунгаж болно.

3 дугаар зүйл

1. Хүлээн авагч улсад суугаа дипломат болон консулын төлөөлөгчийн газрын гишүүнээр томилогдсон, хүчин төгөлдөр дипломат, албан болон тусгай паспорттай Бүгд Найрамдах Чили Улсын иргэд Монгол Улсын нутаг дэвсгэрт албан томилолтынхоо хугацаанд визгүй зорчиж, байж, гарч болно.

Энэ эрх ямба нь дээр дурдсан хүний гэр бүлийн гишүүд, асран хамгаалалд нь байдаг хүмүүст мөн хамаарна, тэхдээ тэд хүчин төгөлдөр дипломат, албан болон тусгай паспорттай байх ёстой.

2. Хүлээн авагч улсад суугаа дипломат болон консулын төлөөлөгчийн газрын гишүүнээр томилогдсон, хүчин төгөлдөр дипломат болон албан паспорттай Монгол Улсын иргэд Бүгд Найрамдах Чили Улсын нутаг дэвсгэрт албан томилолтынхоо хугацаанд визгүй зорчиж, байж, гарч болно.

Энэ эрх ямба нь дээр дурдсан хүний гэр бүлийн гишүүд, асран хамгаалалд нь байдаг хүмүүст мөн хамаарна, тэхдээ тэд хүчин төгөлдөр дипломат болон албан паспорттай байх ёстой.

3. Энэ зүйлийн 1, 2-т заасан албан тушаалтан томилогдон очих тухай илгээгч улсын Гадаад хэргийн яам хүлээн авагч улсын Элчин сайдын яаманд урьдчилан мэдэгдэнэ.

4 дүгээр зүйл

Энэхүү Хэлэлцээрт дурдсан паспорт эзэмшигчид хилийн эрх бүхий байгууллагаас тогтоосон аливаа боомтоор Монгол Улс болон Бүгд Найрамдах Чили Улсын нутаг дэвсгэрт орж, гарч болно.

Энэхүү Хэлэлцээрт заасны дагуу визээс чөлөөлөх нь гадаадын иргэд орох, байх, гарахтай холбогдсон Монгол Улс, Бүгд Найрамдах Чили Улсын хүчин төгөлдөр хууль тогтоомжийг сахиж мөрдөх үүргээс тухайн паспорт эзэмшигчдийг чөлөөлөхгүй.

5 дугаар зүйл

Хоёр Тал тухайн этгээдийг оруулах буюу байлгах нь тааламжгүй гэж үзвэл нутаг дэвсгэртээ оруулах буюу байлгах зөвшөөрөл олгохоос татгалзах эрхээ хадгалж үлдээв.

6 дугаар зүйл

Тал бүр нийтийн дэг журам сахиулах, аюулгүй байдлаа хангах, эсхүл нийтийн эрүүл мэндийг хамгаалах шалтгаанаар энэхүү Хэлэлцээрийн үйлчлэлийг бүхэлд нь буюу хэсэгчлэн түр зогсоож болно. Ийнхүү түр зогсоосон болон зогсоосноо цуцалсан тухайгаа нөгөө Талд дипломат шугамаар даруй мэдэгдэнэ.

7 дугаар зүйл

Хоёр тал энэхүү Хэлэлцээр хүчин төгөлдөр болохоос гуч /30/ хоногийн өмнө энэхүү Хэлэлцээрийн 1, 2 дугаар зүйлд заасан зорчих баримт бичгүүдийн загварыг шинж тэмдэг, хэрэглэх зааврын хамт дипломат шугамаар солилцоно.

Хоёр тал тухайн баримт бичиг болон түүнийг хэрэглэх заавар өөрчлөгдсөн тухай бүрт харилцан мэдээлж, зорчих шинэ баримт бичгийн загварыг хэрэглэхээс гуч /30/ хоногийн өмнө нөгөө Талд өгнө.

8 дугаар зүйл

1. Энэхүү Хэлэлцээрийг хүчин төгөлдөр болгох дотоодын шаардлагаа биелүүлсэн тухайгаа нөгөө Талдаа мэдээлсэн нэг Талын сүүлчийн мэдээлэл өгсөн өдрөөс хойш жар /60/ хоногийн дараа энэхүү Хэлэлцээр хүчин төгөлдөр болно.

2. Хоёр тал тохиролцон энэхүү Хэлэлцээрт оруулж болох нэмэлт өөрчлөлтийг ноот бичиг солилцон мэдэгдэх бөгөөд уг нэмэлт өөрчлөлт энэ зүйлийн 1-д заасны дагуу хүчин төгөлдөр болно.

3. Энэхүү хэлэлцээр хугацаагүй үйлчилнэ. Аль нэг Тал нөгөө Талдаа дипломат шугамаар бичгээр мэдэгдэж түүнийг цуцалж болно. Энэ тохиолдолд

энэхүү Хэлэлцээр нь нөгөө Талын мэдэгдлийг хүлээн авснаас хойш жар /60/ хоногийн дараа хүчингүй болно.

2003 оны есдүгээр сарын 25-ны өдөр Сантьяго хотноо монгол, испани, англи хэлээр үйлдсэн бөгөөд эх бичвэрүүд адил хүчинтэй байна. Орчуулгын зөрүү гарвал англи хэлээрх эх бичвэрийг баримтална.

**МОНГОЛ УЛСЫН
ЗАСГИЙН ГАЗРЫГ ТӨЛӨӨЛЖ**

Гарын үсэг

**БҮГД НАЙРАМДАХ ЧИЛИ
УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫГ
ТӨЛӨӨЛЖ**

Гарын үсэг